

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.04.30-05.04

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын зах зээлийн индексүүд өөр өөр үзүүлэлттэй хаагдлаа.

Apple компанийн 2018 оны 1-р улирлын тайлан гарч, тус компанийн ашгийн үзүүлэлт өндөр байсантай холбогдуулан хувьцаа нь өсөн Nasdaq индекст эерэгээр нөлөөлжээ.

S&P 500 индекст багтдаг мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн бол эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцааны ханш унасан байна. Үүнд эдгээр компаниудын 1-р улирлын орлогын тааруу үзүүлэлтүүд болон АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар эмийн үнийг хянах зарим нэг арга хэмжээ авах талаар мэдэгдэл хийсэн явдал нөлөөлсөн аж.

АНУ-ын Хөдөлмөрийн яамны 4-р сарын ажил эрхлэлтийн тойм гарчээ. Тус тоймд дундаж цалингийн хэмжээ нэмэгдэн, ажилгүйдлийн түвшин 3.9%-аар буурсан талаар тусгасан байв.

АНУ-ын Холбооны нөөцийн банк богино хугацааны бодлогын хүүг өөрчлөхгүй байхаар шийдвэрлэсэн байна.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны асуудал зах зээлд нөлөөлсөөр байна. АНУ-ын худалдааны асуудал хариуцсан төлөөлөгчид БНХАУ руу 2 өдрийн айлчлал хийсэн ч тодорхой үр дүн хүрээгүй ба тус төлөөлөгчид БНХАУ-ын Ерөнхийлөгчтэй ч уулзаж чадаагүй ажээ. Түүнчлэн, энэ долоо хоногт БНХАУ АНУ-аас шар буурцаг худалдан авахаа бүр мөсөн зогсоосон хэмээн мэдээлсэн билээ.

Европ: Компаниудын 2018 оны 1-р улирлын орлогын өндөр үзүүлэлтүүд болон еврогийн ханш сулран экспортыг дэмжиж байгаа нь европын индексүүд өсөхөд нөлөөлжээ.

Европын орнууд дунд Итали улсын компаниудын хувьцааны ханш хамгийн ихээр өсөв. Европын төв банк тус улсын бодлогын хүүг бууруулахад туслалцаа үзүүлснээр италийн санхүүгийн хэрэгслүүд илүү анхаарал татах болжээ. Түүнчлэн, Итали улсын эдийн засаг өсөн, тус улсын банкууд чанаргүй зээлээ хааснаар бизнесийн орчин сайжирч байна.

Япон: Nikkei 225 индекс 6 долоо хоног дараалан өсжээ. Иений ханш ам. долларын эсрэг 109.2 нэгж болсон нь 2017 оны сүүлчээс 3.1%-аар чангарсан байна.

Nikkei-н үйлдвэрлэлийн салбарын худалдан авах менежерийн индекс (PMI) 4-р сард 53.8 хүрч өнгөрсөн сарын үзүүлэлтээс 0.7-оор өсжээ. PMI индексийн сүүлийн үзүүлэлт тус улсын эдийн засаг энэ оны 1-р улирлын удааширлаасаа гарч байгааг илтгэж байна. Иений ханш чангарсан нь экспортын хэмжээг бууруулж байгаа билээ.

Япон улсын төв банк тус улсын эдийн засаг 1.4%-аар өснө хэмээн таамаглаж байсан бол тус байгууллага 1-р улирлын тайландаа эдийн засаг энэ онд 1.6%-аар өснө хэмээн үзжээ.

БНХАУ: Хятадын үйлдвэрийн салбарын PMI индекс 4-р сард буурч 51.4 болсон байна.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,882.54	-1.32% ▼
Dow Jones	АНУ	24,262.51	-0.20% ▼
S&P 500	АНУ	2,663.42	-0.24% ▼
Nasdaq	АНУ	7,209.62	1.26% ▲
S&P/TSX	Канад	15,729.40	0.39% ▲
FTSE 100	Их Британи	7,567.14	0.87% ▲
S&P/ASX 200	Австрали	6,062.90	1.84% ▲
Nikkei 225	Япон	22,472.78	0.02% ▲
Hang Seng	Хонг Конг	29,926.50	-1.17% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	108.45
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	95.22
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	94.53
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.65
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.23
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.62
TDBM' 2020	USD	9.3%	106.35

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Үөү
Libor 1M	1.928	0.02 ▲
Libor 3M	2.369	0.01 ▲
Libor 6M	2.520	0.00 ▲
Libor 1YR	2.777	0.00 ▼
US 6M Bond	2.025	0.02 ▲
US 2YR Bond	2.493	0.01 ▲
US 3YR Bond	2.628	0.01 ▲
US 5YR Bond	2.780	-0.02 ▼
US 10YR Bond	2.946	-0.01 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.05.04	Өөрчлөлт
USD	2,402.60	0.04% ▲
CNY	378.10	-0.17% ▼
EUR	2,875.31	-0.86% ▼
RUB	38.02	-0.52% ▼
KRW	2.23	-
JPY	22.03	0.36% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,314.50	-0.72% ▼
Мөнгө /spot/	16.53	0.12% ▲
Зэс	308.55	0.52% ▲
Нүүрс	97.60	3.20% ▲
WTI газрын тос	69.72	2.38% ▲
Brent газрын тос	74.87	0.31% ▲
Байгалийн хий	2.71	-2.17% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018.III	6.60%
Бодлогын хүү	2018.III	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.III	10.07%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.III	12.80%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.III	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.III	19.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.III	11.30%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 48 компанийн 571.4 сая төгрөгийн 4,128,867 ширхэг хувьцаа арилжигдав.

“Усжуулах” /CMD/ компанийн хувьцаа 32.25%-аар буюу хамгийн ихээр өсч 330.62 төгрөгт хүрч хаагдсан бол “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” /JLT/ компанийн хувьцаа 33.12%-аар буурч 160.50 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр 1 удаагийн хэлцлээр нийт 341 ширхэг үнэт цаас 33.7 сая төгрөгөөр арилжаалагджээ.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр 2,940 ширхэг үнэт цаас 294 сая төгрөгөөр арилжигдсан байна.

5-р сарын 4-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,468.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,882.54 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.32%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	899.1
Зах зээлийн үнэлгээ	2,468,077.7

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,882.54	-1.32% ▼
MSE I индекс	9,745.69	-0.28% ▼
MSE II индекс	9,906.61	0.15% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛендМН ББСБ	3,325,091	147,841,600
Жинст-Увс	59,546	100,277,667
Говь	3,840	84,416,460
АПУ	105,304	66,392,445
Таван Толгой	6,285	64,327,150

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Усжуулах	330.62	32.25% ▲
Талын гал	15.87	15.00% ▲
Хөвсгөл алтан дуулга	9,305.00	14.95% ▲
Их Барилга	3,700.00	12.12% ▲
Монгол савхи	850.00	8.70% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	160.50	-33.12% ▼
Блюскай секьюритиз	1,800.00	-14.85% ▼
Мерекс	30.00	-9.09% ▼
Монгол нэхмэл	3,004.00	-7.57% ▼
МИК Холдинг	10,510.00	-6.58% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек	167,626,493
Мирэ Эссет Секьюритис Монгол	158,378,224
Бумбат-Алтай	140,686,109
Ард секьюритиз	136,317,528
Стандарт инвестмент	81,464,456

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	625.01	665,124
Таван толгой	10,450.00	530,351
МИК	10,510.00	217,655
Говь	22,000.00	171,625
СҮҮ	218.00	74,992

ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-05/06/18-A0253-0	341.00	33,690,800	98,800	98,800	52	13.454%

КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

Компанийн бондын хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	SUUB-BD-29/06/18-C0006-17.5	618.00	61,800,000	100,000	100,000	52	17.500%
2	SUUB-BD-29/06/18-C0006-17.5	2,322.00	232,200,000	100,000	100,000	52	17.500%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Нийт цэвэр ашиг /сая төгрөг/	Цэвэр ашигт эзлэх хувь /%/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	TTL	Таван Толгой ХК	2140.00	126,923.13	141,054.64	90.0%	2018.03.16	2018.04.03	-
2	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	56.60	587.80	2,329.13	25.2%	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
3	AND	Анд-Энерги ХК	1.27	13.27	121,400.00	0.0%	2018.02.24	2018.03.16	-
4	SUL	Жуулчин дюти фрий ХК	10,000.00	653.62	1,070.68	61.0%	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
5	SUU	Сүү ХК	3.00	1,032.00	2,430.13	42.5%	2018.02.14	2018.04.05	2018.12.31-ний дотор
6	GTL	Гутал ХК	1,270.0	2,055.73	2,492.84	82.5%	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
7	BNG	Баянгол Зочид буудал ХК	355.0	150.19	2,481.23	6.1%	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
8	APU	АПУ ХК	10.0 0	10,641.82	24,871.94	42.8%	2018.02.19	2018.03.29	2018.06.01-ний дотор
9	BTG	Баянтээг ХК	100.00	25.26	1,131.61	2.2%	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
10	MIE	Материалимпекс ХК	10.00	13.68	492.98	2.8%	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
11	HRD	Хүрд ХК	497.00	67.23	694.41	9.7%	2018.02.15	2018.02.23	2018 оны II улиралд
12	MNP	Монгол шуудан ХК	3.68	367.25	911.83	40.3%	2018.02.13	2018.04.13	2018.05.01-с
13	MMX	Махимпекс ХК	100.00	380.07	354.75	107.1%	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
14	TCK	Талх чихэр ХК	170.00	174.03	1,128.02	15.4%	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
15	GHC	Ган Хийц ХК	100.00	24.20	(158.94)	-	2018.02.09	-	-
16	ADL	Адуун чулуун ХК	130.00	409.67	435.50	94.1%	2018.01.24	2018.03.01	-
17	UBH	Улаанбаатар хивс ХК	100.00	40.48	247.12	16.4%	2018.02.05	2018.02.26	2018.05.01-ний дотор
18	ТАН	Тахь-ко ХК	108.00	128.52	790.06	16.3%	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
19	GOV	Говь ХК	220.00	1,716.25	17,474.71	9.8%	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с
20	HRM	Гермес Центр ХК	5.00	392.72	715.41	54.9%	2018.01.24	2018.02.15	2018.03.06-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

СЗХ: “Монгол базальт” хаалттай ХК-ийг нээлттэй ХК болгон өөрчлөв

СЗХ-ны ээлжит хуралдаан 5-р сарын 4-нд болж өнгөрлөө.

Тус хуралдаанаар “Монгол Базальт” хаалттай ХК нь нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан тус компанийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 56.4 сая ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхээр шийдвэрлэлээ. Үүний 30 хувь буюу 16.9 сая ширхэг хувьцааг тус бүрийг 380 төгрөгийн тогтоосон үнээр нийтэд санал болгон худалдахыг “Монгол Базальт” ХК-д зөвшөөрчээ. Гэхдээ нийтэд санал болгон худалдаалах хувьцааг зах зээлд 100 хувь арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцно. Иймд анхдагч зах зээлийн арилжааг хариуцлагатайгаар зохион байгуулахыг үнэт цаас гаргагч болон андеррайтингийн ба бусад үйлчилгээ үзүүлэгч нарт даалгалаа.

Орон сууцны санхүүжилтийн “МИК ОССК” ХХК-иас хүсэлт ирүүлсний дагуу шинээр байгуулагдсан “МИК актив арван тав” тусгай зориулалтын компанид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгон, тус компаний гаргаж буй 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 30 хүртэл жилийн хугацаатай, орон сууцны зээлээр баталгаажсан нийт 1,364,896 ширхэг баталгаат үнэт цаасыг бүртгэж, тогтоол гаргалаа.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 113,286 ширхэг хувьцааг нэг бүр нь 1,000 төгрөг болгон өөрчилж, улмаар уг хувьцааг 100 хувааж 11,328,600 ширхэг энгийн хувьцаа болголоо. Ингэснээр уг хувьцааны хөрвөх чадвар сайжирч, хоёрдогч зах зээлийн арилжааны эргэлт нэмэгдэх юм. Хувьцааны үнэд өөрчлөлт оруулах болон хувьцааг хуваахтай холбоотой ажиллагааг ажлын 10 өдөрт багтаан гүйцэтгэхийг Хорооны Үнэт цаасны газар, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д үүрэг болгов.

Эх сурвалж: FRC.mn

Үнэт цаасны төлбөр тооцооны шинэчлэгдсэн журмуудыг үнэт цаасны компаниудад танилцууллаа

Үнэт цаасны зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхэд төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчимд суурилсан төлбөр тооцооны Т+2 горимыг эргэн нэвтрүүлэх ажил нэн тулгамдаад байгаа билээ. Энэхүү ажлын хүрээнд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иар ахлуулсан ажлын хэсгийг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны бүрэлдэхүүнтэй байгуулж, үнэт цаасны төлбөр тооцооны Т+2 горимд шилжихэд шаардлагатай 6 багц журмыг шинээр боловсруулаад байна.

Эх сурвалж: MSE.mn



МХБ: IV сард хувьцааны арилжааны 40 хувийг АПУ, “Лэндмн ББСБ” ХК-ийн арилжаа бүрдүүлсэн

Монголын Хөрөнгийн биржийн дөрөвдүгээр сарын хувьцааны арилжааны 40.3 хувийг АПУ болон “Лэндмн ББСБ” ХК-ийн хувьцааны арилжаа бүрдүүллээ. Арилжааны 26 хувийг хөрөнгийн зах зээлийн отгон тоглогч “Лэндмн ББСБ” ХК-ийн хувьцааны арилжаа бүрдүүлсэн байна. Монголын Хөрөнгийн бирж өнгөрсөн сард нийт 2.98 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа, 592.7 сая төгрөгийн Засгийн газрын үнэт цаасны болон 6.8 тэрбум төгрөгийн багцын арилжаа хийжээ. Үүнээс гадна голлох индексүүд дөрөвдүгээр сард уналттай байсан байна. Тухайлбал, ТОП-20 индекс 4.2 хувиар унаж, 19 мянга 800 нэгж болсон бол MSE A индекс хамгийн их хэмжээгээр буюу 6.5 хувиар буурчээ. Ингэснээр зах зээлийн үнэлгээ сарын эцэст 2.47 их наяд төгрөг болж, өмнөх сараас 4.5 хувиар доошилсон байна.

Харин Монголын Үнэт цаасны биржид дөрөвдүгээр сард хувьцааны 136.8 сая төгрөгийн арилжаа явагдаж хамгийн өндөр дүнтэй арилжаа хийгдсэн сар болжээ. Монголын Үнэт цаасны биржээс мэдээлснээр дөрөвдүгээр сарын эхээр цахим арилжаа хийж эхэлснээр арилжааны идэвх эрс нэмэгдсэн байна. Үүнээс гадна тус бирж IPO гаргах хүсэлтэй компаниудыг цахимаар бүртгэдэг болжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ЭТТ ХК: Баруун Цанхийн коксжих нүүрс тонныг нь 68.1 ам.доллараар борлуулж байна

“Эрдэнэс Таван Толгой” ХК одоогоор Баруун Цанхийн нэг тонн коксжих нүүрсийг уурхайн аман дээр 68.1 ам.доллараар, эрчим хүчний нүүрсийг 12-16 ам.доллараар борлуулж байгаа талаар тус компанийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ганхуяг мэдээллээ.

Харин Зүүн Цанхийн нүүрсийг “Chalco” компанитай байгуулсан гэрээний хүрээнд 59.33 ам.доллараар борлуулж байна. Цаашид нэг тонн нүүрсийг 62 ам.доллараар борлуулах санал хүргүүлж, тавдугаар сарын 10-нд “Chalco” компанитай хэлэлцээ хийхээр төлөвлөж байгаа ажээ. Үүнээс гадна энэ оны II улиралд “Энежри Ресурс” ХХК-ийн үйлдвэрт нүүрсээ баяжуулж эхлэх боломжтой гэж үзэж байгаа талаар “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ганхуяг мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Шивээ Овоо” ХК-ийн борлуулалтын орлого 15 хувиар өсөж, цэвэр ашиг нь 3.8 дахин буурав

Монголын Хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй “Шивээ-Овоо” ХК-ийн борлуулалтын орлого 2017 онд 15 хувиар өсөж, 49.3 тэрбум төгрөг болсон талаар баталгаажсан санхүүгийн тайландаа дурдсан байна. Харин тус компанийн цэвэр ашиг 3.8 дахин буурч, 658 сая төгрөг болсон байна. 2017 онд “Шивээ-Овоо” компанийн борлуулалт, маркетингийн зардал болон үйл ажиллагааны бус зардал аль аль нь огцом өссөн нь ашиг буурахад голчлон нөлөөлжээ. Шивээ-Овоо уурхай дотоодын нүүрсний хэрэглээний 28.3 хувийг дангаараа нийлүүлж байгаа бөгөөд ялангуяа Дулааны IV цахилгаан станцын нүүрсний хэрэглээний 50 гаруй хувийг нийлүүлсэн байна. 2017 онд тус компани хоёр сая гаруй тонн нүүрс олборложээ. 2018 онд “Шивээ-Овоо” компани мөн л төдий хэмжээний нүүрс олборлохоор төлөвлөж байна. Хэдий тийм боловч техникийн шинэчлэл болон өрийн асуудал хамгийн их тулгамдаж байгаа гэдгийг тус компаниас өмнө нь мэдээлж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

2016 оноос хойш нүүрсний ханш 2 дахин өсөөд байна

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилгоор дэлхийн улс орнууд нүүрсний нийлүүлэлтээ бууруулж байна. Ингэснээр 2016 оноос хойш нүүрсний ханш хоёр дахин өсөөд байгаа юм. Нүүрсний ханш өссөнөөр "Glencore", "Anglo American", "BHP" зэрэг нүүрсний томоохон компаниудын ашиг эрс нэмэгдэж байна гэж "Bloomberg Intelligence"-ийн шинжээчид үзлээ.

Өнгөрсөн онд нүүрс олборлолтоор дэлхийд тэргүүлэгч 37 компанийн ашиг сүүлийн зургаан жилийн дээд цэгтээ хүрчээ. Тухайлбал, "Glencore"-ийн ашиг хоёр дахин, "BHP"-ийн ашиг зургаа дахин өссөн байна. 2016 оноос БНХАУ-ын Засгийн газраас чанар муутай нүүрс олборлодог уурхайнуудаа хааж, нүүрсний гарцаа танаж эхэлсэн юм. Ингэснээр дэлхийн нүүрсний нийлүүлэлтийн илүүдэл огцом буурч, нүүрсний ханш ойролцоогоор хоёр дахин өсөөд байна. "ВМО"-ийн шинжээчид 2020 он гэхэд нүүрсний илүүдэл бүрэн арилна гэж таамаглажээ. Цаашид ч нүүрсний ханш өсөх төлөвтэй байна юм. Үүний зэрэгцээ дэлхийн томоохон санхүүгийн байгууллагууд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилгоор нүүрсний бизнест оруулах хөрөнгө оруулалтаа зогсоосон нь шинэ төсөл, шинэ уурхайнуудын тоог эрс бууруулсан байна.

Олон улсад нүүрсний ханш өсөж байгаа нь Монгол Улсын эдийн засагт шууд нөлөөлөөд байна. Экспортын 36 хувийг дангаараа бүрдүүлж байгаа нүүрсний гадаад худалдаа 2017 онд 1.3 тэрбум доллараар өсөж, 2.3 тэрбум ам.долларт хүрчээ. Өнгөрсөн онд нүүрсний нийт олборлолтын хэмжээ 7.2 хувь, нүүрсний экспорт өмнө жилийнхээс 29 хувиар буюу 33 сая тонноор тус тус өсжээ.

БНХАУ өндөр чанартай нүүрсний хэрэглээг дэмжиж байгаатай холбоотойгоор Монгол Улсын нүүрс экспортлогчид нүүрсээ баяжуулан гаргахаар төлөвлөөд байгаа юм. Тухайлбал, "Эрдэнэс Тавантолгой" ХК дотоодын компаниудтай хамтран баяжмал гаргах судалгааны ажлаа эхлүүлсэн бол Нарийнсухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж байгаа "SouthGobi Sands", "Өсөх Зоос", "МАК" зэрэг компаниуд түүхий эдээ баяжуулан экспортлох төлөвлөгөөтэй байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



Гашуунсухайт-Ганцмод боомтоор өдөрт 700-800 автомашин нүүрс тээвэрлэн гарч байна

Гашуунсухайт-Ганцмод боомтоор лхагва гарагт 906 автомашин нүүрс тээвэрлэн гарсан талаар боомтын захиргаа мэдээллээ. Үүнээс ойролцоогоор 65 хувь нь "Эрдэнэс Таван Толгой" ХК, 25 хувь нь "Энержи Ресурс", 10 хувь нь орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК-ийнх байжээ. Түүнчлэн Гашуунсухайт-Ганцмодны боомтын нүүрсний гарцыг гурав болгон нэмэгдүүлснээс хойш өдөрт дунджаар 700-800 автомашин нүүрс ачин гаргаж байгаа талаар Гашуунсухайт боомтын захиргаа мэдээллээ. Эргэн сануулахад, Ерөнхий сайд У.Хүрэлсүх БНХАУ-д айлчилсны дараа Ганцмодны нүүрсний гарцыг гурав болгон нэмэгдүүлсэн нь Тавантолгойн бүлэг ордод олборлолт хийж байгаа компаниудад боломж олгож байна. Улмаар нүүрсний экспорт оны эцэс гэхэд 30 сая тоннд хүрэх боломжтой гэж харж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Төвбанкны алт худалдан авалт өмнөх оноос 8 хувиар өсчээ

Монголбанк энэ оны эхний дөрвөн сарын байдлаар 3.3 тонн алт худалдан авчээ.

Тодруулбал өмнөх оны мөн үед 3 тонн алт авч байснаас 257 кг буюу 8 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна.

Өнгөрөгч дөрөвдүгээр сард худалдаж авсан алтны хэмжээ 988.8 кг –д хүрсэн нь өмнөх оны мөн үеэс өсч, 27 хувь буюу 209.4 кг-аар илүү байна. Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 102 мянга 536.15 төгрөг байна.

Эх сурвалж: Montsame.mn

БНХАУ төмрийн хүдрийн зах зээлээ олон улсад нээлттэй болгов

Төмрийн хүдрийн хэрэглээгээр дэлхийд тэргүүлэгч БНХАУ-ын Засгийн газар фьючерс зах зээлүүдээ олон улсын хөрөнгө оруулагчдад нээлттэй болгох бодлого баримталж байна. Тухайлбал, баасан гарагийн өглөөний 09.00 цагаас эхлэн Далянийн Түүхий эдийн бирж гаднын компаниудад төмрийн хүдрийн арилжаанд орох зөвшөөрөл олгож эхэллээ. Эдгээр компаниудад "Glencore", "Mercuria Energy" зэрэг томоохон тоглогчид багтаж байна. Арилжааг нээлттэй болгосноор БНХАУ дэлхийн түүхий эдийн үнэд үзүүлэх нөлөөгөө нэмэгдүүлэх зорилготой байгаа аж. Тус улс дэлхийн төмрийн хүдрийн нийлүүлэлтийн 70 хувийг импортлодог байна. Төмрийн хүдрийн ханш он гарснаас хойш 11 хувиар унаад байгаа юм. Энэ нь олон улсад нийлүүлэлтийн илүүдэл үүссэнтэй холбоотой ажээ. Одоогоос зургаан долоо хоногийн өмнө БНХАУ түүхий газрын тосны юаниар нэрлэсэн анхны фьючерс арилжаагаа хийж эхэлсэн байна. Газрын тосны импортоор дэлхийд тэргүүлэгч БНХАУ-ын хувьд түүхий эдийн ханшийн хяналтаа нэмэгдүүлж, ам.доллар суурьтай брент, Вест Техас зэрэг АНУ, Европын жишиг индексүүдтэй өрсөлдөхөөр зорьж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Xanadu Mines: "Зараа" талбайн 458 метрийн гүнд тонн хөрс тутамд 0.27 грамм алтны илэрц тогтоосон

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Xanadu Mines" компанийн бэлэн мөнгөний үлдэгдэл I улирлын эцэс гэхэд 5.1 сая австрали долларт хүрсэн байна. Түүнчлэн 2018 оны хайгуулын ажлаа амжилттайгаар эхлүүлсэн гэдгийг тус компанийн Гүйцэтгэх захирал Андрию Стьюарт онцоллоо.

Энэ оны эхний улиралд "Xanadu Mines" компани Өмнөговь аймгийн нутагт байрлах "Хармагтай" орддоо хэд хэдэн хэсэгт хайгуул хийсэн байна. Тухайлбал, "Stockwork Hill" хэмээн нэрлэгдсэн хэсэгт 574 метрийн гүнд тонн хөрс тутмаас 0.91 грамм алт, 230 метрийн гүнд 0.5 хувийн агууламжтай зэсийн илэрц тогтоосон байна. Энэ дунд "Зараа" гэж нэрлэгдсэн шинэ талбайг илрүүлсэн нь гол үр дүн байлаа. Энэхүү талбайд 316 метрийн гүнд 0.32 хувийн агууламжтай зэс, 458 метрийн гүнд тонн хөрс тутмаас 0.27 грамм алтны илэрц тогтоожээ. Хайгуулын ажлын шинжилгээг тавдугаар сарын хоёр дахь долоо хоногт эцэслэн гаргахаар төлөвлөж байгаа талаар "Xanadu Mines" I улирлын тайландаа дурдлаа.

"Хармагтай" орд нь "Оюу Толгой"-ийн ордоос хойд зүгт 120 км-ийн зайд, Улаанбаатараас баруун урд зүгт 440 км-ийн зайтай оршдог.

Энэхүү мэдээлэлтэй зэрэгцээд Австралийн Хөрөнгийн биржид даваа гарагийн арилжаа эхлэх үед "Xanadu Mines"-ийн хувьцааны ханш 0.2 австрали доллар болж хэлбэлзээгүй байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Монгол Улсын эдийн засаг сэргэсэн ч хөрөнгө оруулагчид эргэлзсэн хэвээр

Олон Улсын Валютын Сантай хамтран хөтөлбөр хэрэгжүүлснээс хойш нэг жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг сэргэж байна. Хэдий тийм боловч нэг салбараас шалтгаалан огцом уналт, өсөлт ээлжилдэг Монгол Улсын хувьд энэ сэргэлт хэр удаан үргэлжлэх вэ гэдэгт хөрөнгө оруулагчид анхаарч байна. Түүхий эдийн үнэ өсөж, БНХАУ-ын нүүрсний эрэлт сайн байсан нь төсвийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтөд түлхэц болжээ. Ингэснээр далайд гарцгүй Монгол Улс хөгжиж буй орнуудад нүүрлэдэг хямралын ирмэгээс холдсон гэж шинжээчид дүгнэж байгаа юм. Төсвийн зарцуулалтын хяналт сайжирсан нь мөн үүнд нөлөөлжээ. Одоогоос 12 сарын өмнө Засгийн газрын үнэт цаасны хүү бараг 20 хувьд хүрч, өрийн хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүнтэй тэнцэхэд ойртож байсан юм. Мөн гадаад валютын нөөц хоёр сарын импортын хэрэгцээг хангах түвшинд хүрч буураад байсныг Олон Улсын Валютын Сан мэдээлж байна. Харин одоо эдийн засгийн өсөлт 5.1 хувьд хүрч, төсвийн тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний 15 хувьтай тэнцэхүйц хэмжээгээр сайжирч, валютын нөөц гурван тэрбум орчим ам.доллар болоод байгаа юм.

“Монгол Улсын макро эдийн засгийн байдал богино хугацаанд сайтар тогтворжсон” гэж Олон Улсын Валютын Сангийн Ази, Номхон далайн бүс хариуцсан дэд захирал Маркус Родлуар дөрөвдүгээр сард мэдэгдэж байсан юм. Хэдий тийм боловч 11 тэрбум ам.доллараар хэмжигдэж буй Монгол Улсын эдийн засаг томоохон эрсдэлээс холдож чадаагүй байна. Уул уурхайн түүхийн эдийн үнийн өсөлт хэр удаан үргэлжлэхээс их зүйл хамаарахаар байгаа энэ үед бүтцийн шинэчлэл хийх шаардлагатайг Олон Улсын Валютын Сан анхаарууллаа.

Харин “Moody’s” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэл түүхий эдийн үнийн циклээс хамааралтай байгаа талаар мэдэгдлээ. БНХАУ-ын Монголоос импортолсон коксжих нүүрсний хэмжээ гуравдугаар сард өмнөх сараасаа 132 хувиар өссөн байна. Хэдий тийм боловч энэ нь жилийн өмнөхөөс 5.6 хувиар буурсан дүн боллоо.

“Олон улсын хэмжээнд эдийн засаг сэргэсэнээс шалтгаалан түүхий эдийн үнэ өссөн. Монгол Улсын эдийн засаг сэргэсэн нь энэ өсөлтөөс шалтгаалж байгаа” гэж Монголын бондод хөрөнгө оруулж байсан Лутз Ромейер дүгнэжээ. Тэрбээр “Capitulum Asset Management”-ийн хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар ажилладаг байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

2019 оны төсвийн зардлыг 1.3 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцожээ

Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд төсвийн зардлыг 10.9 их наяд төгрөг байхаар тусгасан талаар Сангийн сайд Ч.Хүрэлбаатар мэдээллээ. Өөрөөр хэлбэл төсвийн зардлыг 2018 оныхтой харьцуулахад 1.3 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцсон байна. Ингэснээр ирэх онд төсвийн алдагдал ойролцоогоор хоёр их наяд төгрөг байх аж. Зарлага талд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, тэтгэвэр нэмэх зэрэг зорилтуудыг Засгийн газар тавьжээ.

Эх сурвалж: Mongolbank.mn

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В” хэвээр үлдээх шийдвэр гарав

Стандарт энд Пүүрс агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В” хэвээр үлдээх шийдвэр гаргажээ.

Тодруулбал тус агентлаг нь Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийг “В-”, төлвийг “Тогтвортой” хэвээр, богино хугацааны зээлжих зэрэглэлийг “В” хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн байна.

Стандарт энд Пүүрс агентлагаас Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг хэвээр үлдээхэд төсвийн тэнцэлд түүхий эдийн үнийн өсөлт эерэгээр нөлөөлж, сүүлийн 12 сарын хугацаанд төсвийн зарцуулалт илүү хатуу хяналттай байсан боловч Монгол Улсын төсвийн санхүүжилт эмзэг хэвээр байгааг онцолжээ.

Мөн зээлжих чадавхи сүүлийн үед сайжирсан ч институцийн болон бодлогын орчноос шалтгаалан сул хэвээр байна. Монгол Улсын эдийн засаг 2017 онд хурдацтай өссөн, мөн хөрөнгө оруулалт болон уул уурхайн үйл ажиллагаа эрчимжихийн хэрээр ирэх жилүүдэд бодит ДНБ-ий өсөлт өндөр гарах хүлээлт байгаа. Гэхдээ Монгол Улсын бодлого боловсруулагч байгууллагууд сайн төлөвшөөгүй байгаа болон орлогын түвшин харьцангуй бага байгаа нь үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн байна. Уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүдийн өргөжилт, хөрөнгө оруулалт болон хэрэглээний өсөлтийн нөлөөгөөр 2018-2021 онд Монгол Улсын эдийн засаг дунджаар 5.5 хувиар өснө гэж тооцоолж байна. Түүнчлэн 2018 онд эдийн засаг 5.0 хувиар өснө гэж төсөөлсөн нь Мүүдиз агентлагийн төсөөллөөс даруй 1.2 хувиар өндөр байгаа юм. “Оюу толгой” болон “Таван толгой” зэрэг мега төслүүд нь монголын орлогын түвшинг их хэмжээгээр нэмэгдүүлэх боломжтой ч, нөгөө талаар эрсдэл байсаар байгаа тул тэдгээр эрсдлүүдийг шинжилгээндээ хамруулжээ. Мөн Засгийн газар 2017 оны 4 дүгээр улиралд өр төлбөрийн менежментийг амжилттай хэрэгжүүлж, 2018 оны нэгдүгээр сард төлөх байсан бондын төлбөрийн эргэн төлөлтийн асуудлыг шийдвэрлэсэн. Энэ нь Монгол Улс сүүлийн жилүүдэд тулгараад буй хүндрэл бэрхшээлийг үл харгалзан дэлхийн зах зээлээс санхүүжилт босгох чадвартайг харуулж байна. Нөгөөтэйгүүр Засгийн газрын болон гадаад өрийн хэмжээ өндөр байгаа нь зээлжих зэрэглэлд сөргөөр нөлөөлж байгааг тодотгосон байна. Тодруулбал урсгал дансны алдагдлын хэмжээ ихсэж, ДНБ-д эзлэх хувь 2018-2020 онд хоёр оронтой тоонд хүрэхээр байгаа нь гадаад секторын нөхцөл байдал эмзэг байгааг харуулж буй аж. Гэхдээ 2017 онд Төв банкны гадаад валютын албан нөөц их хэмжээгээр өссөн нь зээлжих зэрэглэлд эерэг нөлөө үзүүлснийг онцолжээ.

Оюу толгой, Таван толгой зэрэг уул уурхайн мега төслүүдийн хэрэгжилт хүлээлтээс өндөр байж, цаашлаад түүхий эдийн үнэ өсөх, гадаад эрэлт их байх зэргээс шалтгаалан эдийн засгийн өсөлт дараагийн нэг жилийн хугацаанд тус агентлагийн төсөөллөөс давсан тохиолдолд зээлжих зэрэглэлийг сайжруулах боломжтой юм байна. Харин Монгол Улсын макро эдийн нөхцөл байдал бодитоор муудсан тохиолдолд, зээлжих зэрэглэлийн үнэлгээг бууруулах эрсдэлтэй аж. Тухайлбал, гадаад секторын болон төсвийн байдал ихээхэн муудвал Засгийн газрын өрийн эргэн төлөх дарамтыг нэмэгдүүлнэ. Гэхдээ тус агентлаг зээлжих зэрэглэлийн үнэлгээг хийхдээ ирэх 12 сарын хугацаанд дээрх сөрөг нөхцөл байдал үүсэх магадлал маш бага гэж үзжээ.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.